



СОЁЛЫН ТӨВ ӨРГӨӨНИЙ  
2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

УЛААНБААТАР ХОТ

## Гарчиг

1.Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, үр дүн .....	3
2. Тогтоол, шийдвэрийн хэрэгжилт, үр дүн .....	4-5
3. Байгууллагын үйл ажиллагааны үр дүн .....	5-31
4. Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдал .....	31-32
5. Цаг үеийн шаардлагаар хийсэн ажлын үр дүн .....	32-48

## СОЁЛЫН ТӨВ ӨРГӨӨНИЙ 2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

### Нэг. Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, үр дүн:

**Өргөө нь** Монгол Улсын хууль, Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 хөтөлбөр, Улсын Их Хурлаас 2012 онд баталсан “Төрөөс соёлын талаар баримтлах бодлого, Засгийн Газраас батлагдсан төсөл хөтөлбөр, Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт тусгагдсан “Нийслэлийн хүн амд үзүүлэх соёл, урлагийн үйлчилгээний нэр төрлийг олшруулах, хүртээмжийг нэмэгдүүлэх, соёл урлагийн гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх” зорилтууд, байгууллагын үйл ажиллагаанд мөрдөхөөр батлагдсан дүрэм, журам, зааврыг хэрэгжүүлж ирлээ. Тухайлбал:

- Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай” хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулиар төрийн үйлчилгээний албанд тавигддаг зарчим, шаардлага болон холбогдох заалтууд, нийслэлийн өмчийн эд хөрөнгийг бэлтгэх, бүртгэх, ашиглах, хамгаалах, түрээслэхэд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Архивын тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, НИТХ-ын тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллаж ирлээ.
- Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт нутгийн захиргааны байгууллагуудын бодлого, үйл ажиллагаа, хэрэгжилт, үр дүн бүх түвшинд ил тод нээлттэй, хариуцлагатай болж, иргэдийн хяналтыг бий болгон, сайн засаглалтай хот болгохоор дэвшүүлсэн зорилтыг байгууллагынхаа үйл ажиллагаанд хэрэгжүүлж ажиллаж байна.

Гэвч “Дэлхийн улс орнуудад тархаад байгаа “Коронавирус /COVID-19/ цар тахлаас урьдчилан сэргийлэх, нийслэлийн иргэдийн эрүүл мэндийг халдварт өвчнөөс хамгаалах” талаар Засгийн газар, Улсын болон нийслэлийн онцгой комисс, Нийслэлийн Засаг даргаас өгсөн үүрэг, даалгаврыг хэрэгжүүлэхэд байгууллага, хамт олон идэвх санаачлага гарган, иргэдийн хөл хөдөлгөөнийг хязгаарлахад **хяналт тавих-эргүүл хийх, мөн ариутгал, цэвэрлэгээг чанарын өндөр түвшинд хийх, “Сайжруулсан шахмал түлш болон түүхий нүүрсний хэрэглээ түүний зохион байгуулалтын үйл ажиллагаанд хяналт тавих” ажлын хүрээнд шуурхай штабын зохицуулагчийн ажилд оролцох, Тулгар төрийн 2228, Их Монгол Улс байгуулагдсаны 814, Тусгаар тогтнол, үндэсний эрх чөлөөний хувьсгалын 109, Ардын хувьсгалын 99 жилийн ойн төрийн их баяр наадмын хүндэтгэлийн концертын бэлтгэл сургуулилт, телевизийн бичлэгийг мэргэжлийн урлагийн байгууллагуудтай хамтран гүйцэтгэх, зэрэг тусгай үүргүүдийг амжилттай хэрэгжүүллээ.**

## Хоёр: Тогтоол, шийдвэрийн хэрэгжилт, үр дүн.

### 2.1. Байгууллагын үйл ажиллагааг тайлагнах хугацаа.

Байгууллагын үйл ажиллагааны тайланг Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 01 дүгээр хавсралтын дагуу бодлогын баримт бичиг, захирамжлалын баримт бичгийн хэрэгжилтийг хагас, бүтэн жилийн байдлаар гаргаж, холбогдох материалын хамт НЗДТГ-ын Хяналт Шинжилгээ Үнэлгээний хэлтэст хүргүүлж хэвшсэн болно.

### 2.2. Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилт.

Засгийн газрын 2017 оны 243 дугаар тогтоол, Засгийн газраас 2018 онд баталсан “Төрийн албаны сахилга, хариуцлага, дэг журмыг чангатгах” 258 тогтоол, нийслэлээс 2018 оныг “Хариуцлагын жил” болгож, 2019 оны 33 дугаар тогтоолоор баталсан “Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”, Засгийн газрын 2019 оны 7 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам”-ыг ажлын хүрээнд байгууллагын ажилд тогтоосон сахилга хариуцлага, дэг журмыг 2020 оны үйл ажиллагаандаа хэвшил болгон ажиллаж ирлээ. Үүнд:

1. Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор баталсан “Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийн хэрэгжилтийг ханган ажиллах, холбогдох заалтыг байгууллагын дотоод журамд тусгаж хэрэгжүүлж байна. Цаашид Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор баталсан “Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийн 1.2 дах заалтыг үндэслэн байгууллагын чиг үүрэг, үйлчилгээний онцлогийг харгалзан албан хаагчдын ёс зүйн дүрмийг боловсруулан гаргаж, мөрдөж ажиллаж байна.
2. Байгууллагын үйл ажиллагаанд тогтоосон дэг журмыг зөрчиж, ажилдаа хариуцлагагүй хандсан, удирдлагын үүрэг даалгаврыг биелүүлээгүй, ажлын байрны мэргэжлийн шаардлагыг хангаж ажиллаагүй, 2 албан тушаалтанд зохих хууль, журмын дагуу сахилгын зөрчил ногдуулж, арга хэмжээ авлаа.
3. Албан хаагчдын сахилга, үйл ажиллагааны аюулгүй байдлыг 32 камераар байнга хянаж, албан хаагчдын ажилд ирсэн, явсан цагийг хурууны хээгээр бүртгэж үйл ажиллагаандаа хэвшүүлсэн болно. Мөн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Засгийн газрын 2017 оны 243 дугаар тогтоол, байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын холбогдох заалтуудыг үндэслэн Соёлын Төв Өргөөний “Албан хаагчдын дагаж мөрдөх хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны дүрэм”, албаны “Албан хаагчдын дагаж мөрдөх хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны журам”-ыг баталж, хэрэгжүүлж эхэллээ.
4. Захирал, ахлах нягтлан бодогч нар хувийн ашиг сонирхолын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдлийг хуулийн дагуу гаргаж өгсөн.
5. Шилэн дансны хуулийн дагуу 2020 онд санхүүгийн мэдээллүүдийг цаг хугацаанд нь шилэн дансны нэгдсэн системд оруулж ажиллалаа. Энд батлагдсан төсөв сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн харьцуулалт, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлого зарлагын гүйлгээ зэрэг багтаж байгаа юм. Мөн шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээ, мэдээллийн үнэн зөв байдлыг хариуцан ажиллаж, тайланг цаг тухайд нь Сангийн яаманд илгээж байна. 2020 онд нийт 151 шилэн дансны мэдээлэл оруулахаас 2020 онд 151 мэдээлэл байршууллаа.



Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд төсөв, санхүүгийн сахилга батыг чанд мөрдөн ажилласан. Сар шинийн баяр, улсын баяр наадмын амралтын өдрүүдэд хариуцлагатай жижүүрийн хуваарийг захирлын тушаалаар томилон ажиллаж, техникийн ямар нэгэн саад гэмтэл, осолгүй хэвийн ажиллагааг ханган ажиллалаа.

6. Төрийн албаны тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1, Засгийн газрын 2019 оны 7 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам”-ын хэрэгжилтийг хангаж, 2020 онд өндөр насны тэтгэвэрт гарсан 7 албан хаагчид 129225.0 мянга, гачигдлын улмаас 7 албан хаагчдын ар гэрт нь 4165.0 мянга, нийт 133390.0 мянган төгрөгийн буцалтгүй тусламж олголоо.
7. Архивын тухай хуулийг хэрэгжүүлж, байгууллагын архивын сүлжээнд хадгалагдаж буй 1986-2019 онд хамрагдах 3073 захирамжлалын баримтын цахим баримт, тэдгээрт хавсаргасан цахим хувь, хавсралтын бүрдлийн үг үсгийн алдааг нягтлан шалгаж, дутуу бүрдэлтэй баримтыг нөхөн оруулж, цахим баримтын бүртгэл үйлдэв. Мөн 2020 оны хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг гарган байгууллагын ББНШК-оор хэлэлцүүлэн батлуулав
8. Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд төсөв, санхүүгийн сахилга бат, гүйцэтгэлийн хариуцлагын талаарх хууль тогтоомжийг мөрдөж, ажиллаж ирлээ. 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хөндлөнгийн аудитыг нийслэл дэх Төрийн аудитын газраар хийлгэж **“Санхүүгийн тайлангаа холбогдох хууль, санхүүгийн тайлангийн олон улсын стандарт, нягтлан болох бүртгэлийн олон улсын стандарт, түүнд нийцүүлсэн холбогдох заавар журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн, санхүүгийн зөрчилгүй”** гэсэн дүгнэлт авсан.

#### Гурав. Байгууллагын үйл ажиллагааны үр дүн:

##### **3.1. Хүн амд үзүүлэх соёл урлагийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд хийсэн ажил, үр дүн.**

Өргөө нь байгууллагын дүрмээр хүлээсэн “Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан соёл урлагийн бодлого зорилтыг хэрэгжүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлж, “Нийслэлийн хүн амд соёл урлагаар үйлчлэх үйлчилгээний нэр төрлийг олшруулах, хүртээмжийг нэмэгдүүлэх” үүргийн хүрээнд үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу зарим ажлаа хэрэгжүүлж эхэллээ. Тухайлбал: 2020 оны 1 дүгээр сард Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч С.Амарсайхан “Нийслэлийн боловсролын салбарын ажилтнуудтай хийсэн уулзалт”, 6-р сард Монгол Улсын ерөнхий сайд У.Хүрэлсүх “Боловсролын салбар, Төрийн цэргийн болон Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгай чиг үүргийн байгууллагуудын албан хаагчидтай, ЭМЯ-ны харъяа эмч, эмнэлгийн ажилтнуудтай хийсэн уулзалт”, зэргийг зохион байгууллаа.

“Дэлхийн улс орнуудад тархаад байгаа “Коронавирус /COVID-19/ цар тахлаас урьдчилан сэргийлэх, нийслэлийн иргэдийн эрүүл мэндийг халдварт өвчнөөс хамгаалах” тухай Засгийн газар, Улсын болон нийслэлийн онцгой комисс, Нийслэлийн Засаг даргаас гаргасан шийдвэрээр “Улсын хэмжээнд өндөржүүлсэн бэлэн байдал зарлаж, соёл урлаг, олон нийтийн үйл ажиллагааг зогсоосон болохоор хүн амд үзүүлэх соёл урлагийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилтоо хэрэгжүүлэх боломж энэ оныг дуустал хязгаарлагдлаа.

Гэвч Тулгар төрийн 2228, Их Монгол Улс байгуулагдсаны 814, Тусгаар тогтнол, үндэсний эрх чөлөөний хувьсгалын 109, Ардын хувьсгалын 99 жилийн ойн төрийн их баяр наадмын хүндэтгэлийн концертын бэлтгэл сургуулилт, телевизийн бичлэгийн үйл ажиллагааг мэргэжлийн урлагийн байгууллагуудтай

хамтран, цахимаар шууд дамжуулах арга хэмжээнд амжилттай сайн оролцож, ажиллалаа.









Монгол Улсын Нийслэл Улаанбаатар хотын 381 жилийн ойн баярын Хүндэтгэлийн концерт Нийслэлийн Соёлын Төв өргөөнд 2020 оны 10 дугаар сарын 29-ны өдөр 15:00 цагт тоглолоо. Хүндэтгэлийн концертын ерөнхий зохион байгуулагчаар Нийслэлийн Соёлын Төв Өргөөний хамт олон бүрэн бүрэлдэхүүнээрээ ажиллалаа. Хүндэтгэлийн концертыг Нийслэлийн ИТХ-ын дарга Ж.Батбаясгалан, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Д.Сумъяабазар тэргүүтэй холбогдох албаны хүмүүс, нийслэлийн үе үеийн удирдлагууд, иргэд олон нийт хүрэлцэн ирж, таалан соёрхлоо.



Улаанбаатар хотын 381 жилийн ойд зориулсан энэхүү хүндэтгэлийн концертын ерөнхий найруулагчаар Төрийн соёрхолт, Монгол Улсын Урлагийн гавьяат зүтгэлтэн Сэвжидийн Сүхбаатар, Концертын ерөнхий захирлаар Соёлын Төв Өргөөний захирал, Монгол Улсын Урлагийн гавьяат зүтгэлтэн Бадамын Байгалмаа, туслах найруулагчаар Соёлын Төв Өргөөний уран бүтээл техникийн албаны дарга Д.Баянзул нар ажиллалаа. Монгол улсын нийслэл Улаанбаатар хот 381 жилийнхээ шастир түүхийг бичиглэж яваа нийслэлчүүд энэ өдрүүдэд ойн баяраа хүндэтгэл бахархал, бүтээлч ажил, өрнүүн амжилтаар дүүрэн тэмдэглэж байна. Нийслэлийн 381 жилийн ойд зориулсан Хүндэтгэлийн концерт Соёлын төв өргөөнд болж, Үндэсний урлагийн их театр, Дуурь бүжгийн эрдмийн театр, Цэргийн дуу бүжгийн эрдмийн чуулга, Монгол Улсын филармонийн симфони найрал хөгжим, Морин хуурын чуулга, Нийслэлийн “Улаанбаатар” чуулга зэрэг мэргэжлийн урлагийн байгууллагын оркестр, найрал дуучид, бүжигчид, Монгол Улсын урлагийн үе үеийн алдартнууд тэргүүтэй 400 гаруй уран бүтээлч, техник арын албаны ажилтнууд оролцож нийслэлчүүддээ уран бүтээлийн дээжээ өргөн барьлаа.



























**Гоцлол дуучид-** П.И.Чайковскийн нэрэмжит олон улсын дуурийн дуулаачдийн уралдааны гранпри шагналт, ОХУ-ын Марийнскийн театрын гоцлол дуучин, Тэргүүн зэргийн Чингис хаан одонт, МУГЖ Г.Ариунбаатар, МУАЖ Д.Самбуу, МУАЖ А.Долгор, МУГЖ Н.Амгалан, МУГЖ С.Ганзориг, МУГЖ Ө.Уянга, МУГЖ Мөнхбаатар, МУСТА С.Наран, МУСТА Гомбо-Очир, МУСТА Дэлгэрмөрөн, МУСТА Наранбаатар, , МУСТА Наранхүү, МУСТА Бурмаа, Отгонжаргал, Сөрөлт, Түмэн-Өлзий, рэппэр МБ нарын 18 гоцлол дуучид оролцлоо.

Хошин урлагийн Эмоци продакшны “Best of Emotsi” шилдэгийн шилдэг тоглолт тоглогдлоо. Энэ онд 22 удаагийн тоглолт, хурал, лекцийн арга хэмжээнд 19,000 хүнд үйлчилсэн байна. Ковид-19 цар тахлын үед үйлчлэгч нар нь өөрсдийн хариуцсан талбайдаа өдөр тутмын цэвэрлэгээ үйлчилгээ хийхээс гадна үзэгчдийн их танхимын хивсэнцэр, 3-р давхарын фойены хивсэнцэрийн өнгөлгөө, “А”, “Г” байрны подвалд бүх нийтийн их цэвэрлэгээг 14 хоногт 1 удаа тогтмол хийж, өрөө тасалгаанд ариутгалын бодистой цэвэрлэгээг өдөрт 2 удаа хийж, шат хаалганы бариул зэрэг хүн их хүрдэг хэсгийг ариутгалын бодистой уусмалаар байнга арчиж, цэвэрлэж байна.


Засгийн газрын 2020 оны “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжих тухай” 178 дугаар тогтоол, Улсын онцгой комиссын 34 дүгээр хурлын тэмдэглэл, Нийслэлийн засаг даргын 2020 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн А/1242 дугаар захирамжуудын тогтоол шийдвэрүүдийг хэрэгжүүлэх, албан хаагчдад танилцуулж гоц халдварт өвчнөөс өөрийгөө, гэр бүлээ, хамаарал бүхий хүмүүсээ хамгаалах талаар заавар зөвлөгөө өгч ажиллаж ирлээ. Цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор халуун хэмжигч, гар ариутгагч, жавелин, блезна, спирт, халуун үзэгч зэргийг худалдан авч, үйлчилгээндээ ашиглаж, “А” болон “Г” зоны жижүүр дээр гар ариутгагчийг байршуулж, гаднаас орж ирж буй албан хаагч, иргэн, үйлчлүүлэгчдийн гарыг ариутгуулах, биеийн халууныг хэмжиж бүртгэл хөтөлж байна.

ЭМЯ болон мэргэжлийн байгууллагуудаас өгч буй халдвараас хамгаалах заавар зөвлөмжийг хэвлэж, шаардлагатай хэсгүүдэд байршууллаа. Хамт олныг бөөгнөрөл үүсгэхгүй, хүн хоорондын зай барихыг зөвлөж, амны хаалт зүүж хэвшлээ. UB ERP системийг ашиглан цахимаар албан бичгүүдээ илгээж, хүлээн авч хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Аж ахуйн нэгж, байгууллагын түрээсийн гэрээний төлбөрийг нэмэгдүүлж өөрчлөөгүй. Байгууллагын албан ёсны вебсайтад Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас болон ЭМЯ-аас өгч байгаа зөвлөмж, шаардлагыг тогтмол нийтэлж, “Маскаа зүүе, гараа угаая” аяны талаар тогтмол сурталчилж ажиллав. “Мөн “Г” зонд ажлын өдрүүдэд хариуцлагатай жижүүр ажиллуулж түрээслэгч байгууллагуудын ажилтан албан хаагчид, тэдэнтэй уулзах иргэдийн бүртгэлийг хөтөлж байна. Qr.119.mn- ээс Соёлын Төв өргөөг тодорхойлсон QR кодыг хэвлэн байгууллагын хоёр нэвтрэх хэсэгт 12 сарын 01-нээс байршуулж, орсон хүн бүрийг QR кодыг уншуулж, орох шаардлагыг тавьж ажиллаж байна.

Коронавирусийн халдварын ойрын болон дам хавьталд орсон хүн үзвэр үзсэнтэйгээр холбогдуулан халдвараас урьдчилан сэргийлэх тархалт хүрээг нь нэмэгдүүлэхгүйн тулд тусгай зөвшөөрөл бүхий мэргэжлийн байгууллагатай хамтран ариутгал халдваргүйтгэлийн ажлыг 2020 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр Нийслэлийн Соёлын Төв Өргөөний Концертын их танхим, гадна болон дотоод орчны талбай бусад өрөө тасалгаа зэрэгт /нийт 3000 орчим метр квадрат/ талбайд ариутгал, халдваргүйжүүлэх ажлыг тусгай зөвшөөрөл бүхий “Түвшинбилэг Төгөлдөр” ХХК мэргэжлийн байгууллагатай хамтран хийлгэлээ.









### 3.2 Байгуулагын менежментийг боловсронгуй болгох, өмчийн ашиглалтыг сайжруулах талаар:

Өргөө нь байгууллагын дүрмээр хүлээсэн “Нийслэлийн өмчийн барилга байгууламж, эд хөрөнгийг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад түрээслүүлэх” үүргээ хангалттай хэрэгжүүлж ажиллаж байна. Тухайлбал:

1. Өргөөний цогцолборын дулаан, цахилгаан, ус хангамжийн болон хог хаягдал, лифтийн үйлчилгээний аж ахуйн гэрээг байгуулж төлбөрийг цаг хугацаанд нь барагдуулж найдвартай ажиллагааг хангаж, өвлийн халаалтын дулаан, сантехник, цахилгаан, усан хангамжийн ямар нэгэн доголдол, аваар осолгүй ажилласан болно.

Цахилгаан эрчим хүчний гэрээг 2024 оны 5 дугаар сарын 23-ны өдөр хүртэл 5 жилийн хугацаатай, дулааны эрчим хүчийг худалдах, худалдан авах гэрээг 2028 оны 10 дугаар сарын 01 хүртэл 10 жилийн хугацаатай тус тус сунгалаа.

Түрээслэгч байгууллагуудаас 2020 онд ирсэн санал хүсэлтийг хугацаанд барагдуулж, 4 дүгээр сарын 1-нд салхивч, 5 дугаар сарын 1-нд халаалтаа хааж, засварын ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Өвлийн бэлтгэлийг хангаж ажиллах үүднээс цонх хаалга дулаалах, гаднаас орох хаалгануудын шатанд резин, хивсэнцэр наах, цахилгааны болон дулааны төв узельд их цэвэрлэгээ хийх, гэрэлтүүлгийг шинэчлэх, ялтсан бойлеруудыг угаах, хэрэглээний хүйтэн усны насос, дулаан, цахилгаан хангамжийн тоолуур шинэчлэх зэрэг дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

2. Соёлын төв өргөөний цогцолбор барилгын “Г” хэсгийн 1-р давхарын хүлээлгийн заалыг засаж тохижуулах ажлыг хийлээ. Үүнд: Төв хаалганы хоёр талд байсан хаалт ханыг нурааж, хуучин таазны төмрийг буулган хогийг цэвэрлэн гипсэн хавтангаар уналттай тааз хийн бүх хана таазанд замаска, кнап татаж, шин, фужи обой нааж эмульсдэн ирмэг, буланг хүрээлэв. Мөн эргэн тойрон бүх хананд гоёлын хавтангаар явган хана хийж, хананы дээр, доор болон багануудад гоёлын хүрээ наалган, хоёр талын шалыг паркетлаж, таазанд нүдэн гэрэл, абжур суулгалаа.





3. Барилгын “Г” хэсгийн хүн зөөврийн хоёр ачааны нэг лифтэнд их засвар хийж гүйцэтгэлээ. Үүнд: Лифт тус бүрийн ган татлагануудын эдэлгээний хугацаа дуусч нарийсч эвдэрсэнийг шинээр сольж, засуулаа. Лифт засварын мэргэжлийн “Фушили Элеватор” ХХК-аар бүхээгний хаалгануудын башмак, редукторын тосыг сольсон, ган татлагыг сольсон, хонгилын гэрлийн шугамыг шинээр татсан зэрэг ажлуудыг гүйцэтгүүлж, лифт бүрт даац мэдрэгчийг суурилуулав. Лифт засварын зардалд 13,7 сая төгрөгийг зарцууллаа.







4. Албан хаагчдаа тав тухтай орчинд хооллох, эрүүл чанартай хүнсээр өдрийн хоол цайгаа бэлтгэх нөхцөлийг бүрдүүлж, "А" хэсгийн 306, 307 тоот өрөөнүүдийг амралтын цайны өрөө болгон тохижууллаа. Үүнд: Хана таазанд замаска, кнап татан зүлгүүрдэж эмульсээр будаж, орчин үеийн уналттай тааз хийн, ирмэг, булан, хүрээ хадаж, хананд 3 ди хөөсөнцөр хавтан болон фужи шин обой нааж, ирмэгээр нь гоёлын булан гарган эмжүүлж, модон хаалга суулгав. Амралтын өрөөнд шинээр гал тогооны ком, хөргөгч, плитка, шарах шүүгээ, хөлдөөгч зэргийг суурилуулж, хүнсний материалаа хадгалах боломжоор хангаж өглөө.







2020 онд Соёлын Төв Өргөөний А, Г зонд хийгдсэн засварын ажил болон тохижуулах зардалд нийт **51,5** сая төгрөгийг зарцууллаа.

5. Байгууллагын өвлийн бэлтгэлийг хангах ажлын хүрээнд сантехникийн шугам сүлжээний найдвартай ажиллагааг шалгаж, эргэлтийн хүйтэн усны шугам элэгдэлд орж, үйл ажиллагаа доголдоход хүрснийг тогтоож, яаралтай арга хэмжээ авч, засвар хийлээ. Тус цогцолбор барилга ашиглалтад орсноос хойш эргэлтийн хүйтэн усны шугам сүлжээнд их засвар хийгдээгүйгээс хүйтэн усны хоолойд элэгдэл үүсч, олон газраар цоорон ус шүүрж, задарсан 152 метр хоолойг өөрсдийн хүчээр сольж, шинээр тавилаа. Ингэснээр цэвэр усны алдагдлыг бууруулж, зардлаа хэмнэж, өвлийн бэлтгэлийг хангаж ажиллалаа.

Мөн гадна бохирын шугам бөглөрснийг зориулалтын машинаар буудуулж, бөглөөсийг арилгаж, бохирын шугамын гаднах 21 худгийг лайдаж цэвэрлэв.

#### Цэвэр усны хуучин хоолойн зураг







6.“Г” хэсгийн 1 давхрын ариун цэврийн өрөөний хана, тааз, шалыг иж бүрэн сольж, салхивчны хоолой болон сантехникийн шугамыг сольж, хөгжлийн бэрхшээлтэй иргэд үйлчлүүлэх стандартад нийцүүлэн засаж тохижуулсан.



7.“Г” хэсгийн 12 давхрын ариун цэврийн өрөөний хана, тааз, шалыг иж бүрэн сольж, суултуур, угаалтуур, холигч, салхивчны хоолой болон сантехникийн шугамыг сольж засаж тохижуулсан.




8. Их танхимын дээврийн хэсгийн резин жийргэвч нь нар салхинд элэгдэн тасарч, хүйтэн агаар дотогшоо сийгэн их танхимд дулаан алдагдал үүсгэж байсныг дулаалгын хөөс болон хөөсөнцрөөр битүүмжилж дулааны алдагдлыг бууруулж ажиллалаа.



9. 2020 оны өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд А болон Г хэсэгт цоорч муудсан 12 ширхэг халаалтын радиаторыг сольж, 21 ширхэг халаалтын радиаторыг угааж, усны дүүргэлт хийснээр 10 дугаар сарын 1-нд халаалтыг бүрэн авч, дулаан, сантехник, цахилгааны доголдолгүй, аваар осолгүй ажиллалаа.





10. Дээврийн ус зайлуулах шугам хоолой 3 хэсэг газарт бөглөрснийг арилгаж, хөлдсөн хэсэгт гагнуур хийн засварлав.

11. Дээврийн болон цасны хог хаягдлыг тухай бүрт нь цэвэрлэж хэвшүүлээ.

12. “Г” хэсгийн 521 тоот өрөөнд халуун усны шугамын хоолой цоорч задарсанаас өрөөний хана, таазыг гэмтээснийг эмүльсдэж, будаж, обой наан засвар хийсэн.



13. Дэлхий даяар тархсан Ковид-19 цар тахлын улмаас бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хөл хорионы үед “А” болон “Г” хэсэгт хариуцлагатай жижүүрийг томилон ажиллуулж, бүх байгууллагуудын ажиллагсад болон үйлчлүүлэгчдийг QR код болон регистрийн дугаар, гэрийн хаягаар бүртгэлжүүлж, халууныг хэмжин, гарт ариутгал хийх ажлыг бүрэн хэвшүүлээ.







14. Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбоотойгоор ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх үүднээс хүн зөөврийн 4 лифтэнд гар ариутгалын шингэнийг зориулалтын саванд хийж байрлуулав.



#### 4.1. Төсвийн орлогын бүрдүүлэлт, төвлөрүүлэлтийн тухай.

Манай байгууллага түрээсийн буюу үзвэр үйлчилгээ, арга хэмжээний орлогоор үйл ажиллагааны санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлж, батлагдсан төсөв, үр дүнгийн гэрээний хүрээнд зардал гарган, төсвийн санхүүжилтийг үр ашигтай зарцуулж, санхүүгийн тайланг үнэн зөв бэлтгэж, хуулийн хугацаанд тайлагнаж ирлээ.


2020 онд иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нийлсэн 33 түрээслэгчтэй түрээсийн гэрээ байгуулан, гэрээний биелэлтийг хангуулж, НИТХ-аас баталсан төлөвлөгөөний дагуу үйл ажиллагааны зардлаа санхүүжүүлж, төсвийн сахилгыг чанд сахиж ажиллалаа.

Орлого буурч, нийслэлийн төсөвт мөнгө төвлөрүүлээгүй нь “Дэлхийн улс орнуудад тархаад байгаа “Коронавирус /COVID-19/ цар тахлаас урьдчилан сэргийлэх, нийслэлийн иргэдийн эрүүл мэндийг халдварт өвчнөөс хамгаалах” тухай Засгийн газар, Улсын болон Нийслэлийн онцгой комисс, Нийслэлийн Засаг даргаас гаргасан шийдвэрээр “Улсын хэмжээнд өндөржүүлсэн бэлэн байдал тогтоож, соёл, урлагийн байгууллагуудын үйл ажиллагааг хязгаарласантай холбоотой юм.

**Нийслэлийн Соёлын Төв Өргөөний 2000-2020 онд бүрдүүлсэн орлого, төсөвт төвлөрүүлсэн, үйл ажиллагааг санхүүжүүлсэн мөнгөн хөрөнгийн тооцоо**

Д/д	Он	Нийт бүрдүүлсэн орлого /мян.төг/	Зарлага		Захирамжаар /мян.төг/	Төвлөрү үлэх орлогын төлөвлөгөө /мян.төг/	Хувь
			Зардал санхүүжүүлэх /мян.төг/	Төвлөрүүлсэн орлого /мян.төг/			
1	2000	565,261.6	376666.6	188595		171419.7	110
2	2001	789,100.5	576733	212367.5	10,500.00	176391.7	120.4
3	2002	730,734.7	544884.7	185850	16,950.00	185524.8	105.3
4	2003	704,033.9	496433.9	207600	43,000.00	206400	105.6
5	2004	983,306.7	708514.7	274792	24,050.00	210993.7	135.4
6	2005	1,120,315.8	856616.4	263699.4	87,150.00	263699.4	106.4
7	2006	1,287,005.2	929403.2	357602	98,350.00	345291.8	103.6
8	2007	1,513,564.6	1050507.7	463056.9	6,225.00	375009.6	171.5
9	2008	1,464,915.5	1100407.2	364508.2	50,750.00	364449.2	100
10	2009	1,267,699.4	1017699.4	250000	74,400.00	249340.6	100.3
11	2010	1,388,227.8	1108227.8	280000	88,750.00	280006.2	100
12	2011	1,552,116.9	1239008.6	298428.8	78,575.00	298428.8	100
13	2012	1,694,306.2	1782669.5	450000	44,162.50	304031.9	148
14	2013	1,637,720.6	1372057	380000	147,500.00	377545.2	100.7
15	2014	1,659,664.5	1252664.4	407000	104,500.00	406027.6	100.2
16	2015	1,580,607.1	1157707.1	422900	89,500.00	422000	100.2
17	2016	1,564,740.4	1202740.4	362000	102000	361093.7	100.3
18	2017	1,476,899.4	1109974.5	361247.8	161500	361247.8	100
19	2018	1,396,156.0	1070462.3	325693.7	168500	325193.2	100
20	2019	1,665,383.4	1319455.6	332000	295000	332000	100.2
21	2020	963,758.1	1078049.2	24933.9	49000	0	
	<b>Дүн</b>	<b>27,005,518</b>	<b>21,350,883</b>	<b>6,412,275</b>	<b>1,740,363</b>	<b>6,016,095</b>	

**Нийслэлийн Соёлын Төв Өргөөний 2000-2020 онд бүрдүүлсэн орлого, төсөвт төвлөрүүлсэн, үйл ажиллагааг санхүүжүүлсэн мөнгөн хөрөнгийн тооцоог графикаар харуулвал:**





### 3.4. Байгууллагын хүний нөөцийг чадавхижуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах талаар дараах ажлуудыг хийлээ. Үүнд:

Хүнийг хөгжүүлэх тусам чадвар нь өсөж, боловсорч хөгжихийн хэрээр сэтгэж, сэтгэхийнхээ хэрээр бүтээдэг онцлогтойгоороо бусад нөөцүүдээс давуу талтай юм. **Өөрөөр хэлбэл:** Төрийн байгууллагын зорилт, чиг үүргийг цомхон, мэдлэг чадвартай, гадаад, дотоод орчны өөрчлөлтөнд уян хатан зохицож чаддаг, төрийн албан хаагчдаар гүйцэтгүүлж, иргэдэд ойр, хэрэгцээг нь хангасан чанартай төрийн үйлчилгээг үзүүлэх үүрэг, хариуцлагын тогтолцоог бий болгох, улмаар байгууллагаас олон талт, өргөн цар хүрээтэй мэдлэг чадвар бүхий хүний нөөцтэй байх, хүний нөөцийг тасралтгүй хөгжүүлж байхыг шаарддаг.

Иймд Өргөөний захиргааны зөвлөлийн хуралдаанаас байгууллагын зорилт, чиг үүргийг бүрэн дүүрэн хэрэгжүүлэх, төрийн үйлчилгээг хөнгөн шуурхай явуулахад тоо, чанарын шаардлага хангахуйц хүний нөөцийг бүрдүүлэх, “Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр”-ийг баталж, захиргааны зөвлөлийн гишүүдэд эрхэлсэн ажилтай нь уялдуулан албан хаагчдын эрүүл мэнд, ажлын байрны нөхцөл сайжруулах, техник хэрэгслээр хангах, сургах, мэргэшүүлэх, үйлчилгээ, харилцааны соёл эзэмшүүлэх, хүний нөөцийн мэдээллийн сан бүрдүүлэх, мэдээллийн ил тод байдлыг хангах зэрэг олон ажлыг хийж хэрэгжүүллээ.

Хүний нөөцийг чадавхижуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах талаар жилийн ажлын төлөвлөгөөнд тусгасан зорилтын биелэлтийг Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 10 дүгээр хавсралтын дагуу тооцож гаргалаа.

ХҮНИЙ НӨӨЦИЙГ ЧАДАВХЖУУЛАХ, ТОГТВОР СУУРЬШИЛТАЙ АЖИЛЛУУЛАХ ТАЛААР БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНД ТУСГАГДСАН ЗОРИЛТЫН БИЕЛЭЛТИЙГ ТАЙЛАГНАХ ХҮСНЭГТ						
Зорилт	№	Үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт	Зурилтот түвшин (Тоо хэмжээ, хувь)	Хүрсэн түвшин (Хэрэгжи лтийн хувь, тоо хэмжээ)	Зарцуулсан хөрөнгө, эх үүсвэр гүйцэтгэл зэр (мян.төг)
1. Хүний нөөцийг чадавхжуулах	1	Албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан гадаад, дотоодын сургалт	Дотоод сургалтын тоо	6-аас дээш	4	
			Албан хаагчдын хамрагдсан байдал/ажлын байрны сургалт	100%	67%	
			Гадаад сургалтын тоо /туршлага судалсан/	0		
		2	Мэргэшсэн, туршлагатай хүний нөөцийг бүрдүүлэх	Албан хаагчдын хамрагдсан байдал	2%	100%
<b>Хэсгийн дундаж:</b>						
2. Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах	3	Цалин хөлс, шагнал, урамшууллын тогтолцоог хэрэгжүүлэх	цалин, шагналд хамрагдсан албан хаагчдын тоо	58	100%	459876.0
			Албан хаагчдын үйл ажиллагааны үнэлгээ, ажилласан жил, үр дүнгийн урамшуулал, ур чадварын нэмэгдэл,	7	100%	10577.6
	4	Албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцөлийг бүрдүүлсэн байдал	Ажлын байрны таатай орчны сэтгэл ханамжийн санал асуулга	Сэтгэл ханамж 80%	100%	
			Албан хаагчдад сар бүр олгох хоол, унааны зардалд	58	100%	68214.0
	5	Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх	Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг	0	0	
<b>Хэсгийн дундаж:</b>						
<b>Үнэлгээний дундаж хувь:</b>						100%

**Сургалтын чиглэлээр:** Дээд байгуулагаас цаг үеийн шаардлагаар зохион байгуулагдаж буй сургалт, семинарт тухай бүрд оролцож ирлээ. Тухайлбал:

1. 2020 оны 01 дүгээр сарын 07-ны өдөр Хүний эрхийн үндэсний комисс, Нийслэлийн Засаг даргын тамгын газартай хамтран зохион байгуулсан "Жендэр ба хүний эрх" сургалтад Инженер техникийн албаны дарга Ж.Дуламжав,
2. 2020 оны 01 дүгээр сарын 22-ний өдөр Нийслэлийн Соёл урлагийн Газар зохион байгуулсан "Нийслэлийн Соёл, Урлагийн салбарын ажилтнуудад зориулсан сургалт"-д 8 хүний бүрэлдэхүүнтэй хамрагдав.
3. 2020 оны 5 сарын 11-ний өдрийн 11-13 цагийн хооронд 2020 оны 5 сарын 11-ний өдрийн 11-13 цагийн хооронд Нийслэлийн Архивын газраас зохион байгуулсан "Архив, албан хэрэг хөтлөлтийн онол, арга зүй" сэдэвт алсын зайн сургалтад Архив албан хэрэг хөтлөлт хариуцсан даргын туслах Д.Цогжаргал zoom-ээр хамрагдлаа.
4. 2020 оны 06 сарын 18 -ны өдөр Нийслэлийн дотоод аудитын газар болон Нийслэлийн засаг даргын тамгын газрын санхүү, төрийн сангийн хэлтэстэй хамтран зохион байгуулсан "Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллахад анхаарах асуудлууд" сэдэвт сургалтад тооцооны нягтлан бодогч Д.Гэрэлтуяа нь оролцлоо.
5. Дууны оператор Ч.Батчулуун, дууны техникч А.Батнягт нарыг 2020 оны 06-р сарын 15-16-ны өдрүүдэд "Анир студи"-н найруулагч Алтанхуягийн удирдлага дор симфони оркестрийн хөгжмийн бичлэг хийх дадлага сургалтанд хамрагдсан.
6. Гэрлийн оператор А.Батцэнгэл, Л.Нямцэрэн нарыг 2020 оны 06-р сарын 19-с 07-р сарын 01-ний өдрүүдэд гэрэлтүүлгийн программ хангамжийн сургалтанд хамрууллаа.
7. УБТА-ны дарга Д.Баянзул, зохион байгуулагч Ц.Пүрэвсүрэн нар 2020 оны 08-р сарын 7-ны өдөр НЗДТГ-аас зохион байгуулсан "Төрийн албаны тухай хууль, Гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах арга зүйн" сургалтанд хамрагдлаа.
8. Тооцооны нягтлан бодогч Д.Гэрэлтуяа 2020 оны 11-р сарын 21-24-ний өдрүүдэд "Сангийн яамны цалингийн нэгдсэн систем"-д орох онлайн сургалтанд хамрагдлаа.

**Ажлын байрны чиглэлээр:** Маркетинг үйлчилгээний албанд үйлчлэгчээр Ч.Алтанцэцэг, Г.Ариунтунгалаг, Б.Болормаа нарыг, Санхүүжилт менежментийн албанд Н.Энхбатыг захирал буюу инженерээр, Х.Батмөнхийг жижүүрээр тус тус ажилд авч ажлын байраар хангалаа.

**Албан хаагчдын шагнал, нийгмийн баталгааны чиглэлээр:**

Төрийн албаны тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1, Засгийн газрын 2019 оны 7 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам"-ын хэрэгжилтийг хангаж, 2020 онд өндөр насны тэтгэвэрт гарсан 7 албан хаагчид **129225.0** мянга, гачигдлын улмаас 7 албан хаагчдын ар гэрт **4165.0** мянга, нийт **133390.0** мянган төгрөгийн буцалтгүй тусламж, албан хаагчдын цалин, үр дүнгийн урамшуулалд **459.9** сая төгрөгийг, ур чадварын нэмэгдэлд **10.5** сая төгрөгийг, хоол унаанд **68.2** сая төгрөгийг тус тус олголоо.

Байгууллагын захиргааны зөвлөлийн хуралдаанаас байгууллагын зорилт, чиг үүргийг бүрэн дүүрэн хэрэгжүүлэх, төрийн үйлчилгээг хөнгөн шуурхай явуулахад тоо, чанарын шаардлага хангахуйц хүний нөөцийг бүрдүүлэх, "Хүний

нөөцийн хөгжлийн хөтөлбөр"-ийг баталж, захиргааны зөвлөлийн гишүүдэд эрхэлсэн ажилтай нь уялдуулан албан хаагчдын эрүүл мэнд, ажлын байрны нөхцөл сайжруулах, техник хэрэгсэлээр хангах, сургах, мэргэшүүлэх, үйлчилгээ, харилцааны соёл эзэмшүүлэх, хүний нөөцийн мэдээллийн сан бүрдүүлэх, мэдээллийн ил тод байдлыг хангах, зэрэг олон ажлыг даалгаж, хэрэгжүүлж хэвшсэн юм.

Гэвч Дэлхийн улс орнуудад тархаад байгаа “Коронавирус /COVID-19/ цар тахлаас урьдчилан сэргийлэх, иргэдийн эрүүл мэндийг халдварт өвчнөөс хамгаалах зорилгоор Улсын хэмжээнд өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжиж, улмаар соёл урлагийн байгууллагын үйл ажиллагааг зогсоосон нь зарим албан хаагчдыг хамруулах ёстой ажлын байрны, ганцаарчилсан сургалтыг явуулж чадаагүй бөгөөд эрүүл мэндийн үзлэгт хамруулаагүй байна.

### **3.5. Архив, албан хэрэг хөтлөлт, хариутай албан бичгийн шийдвэрлэлтийн талаар дараах ажлуудыг хийлээ. Үүнд:**

#### **www.edoc.ulaanbaatar.mn-ийг ашиглан:**

Нийслэлийн байгууллагуудад иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн албан бичиг шийдвэрлэхэд ашиглагдаж буй [www.edoc.ub.gov.mn](http://www.edoc.ub.gov.mn) цахим программаар:

**Ирсэн албан бичиг:** Тайлант хугацаанд нийт 175 албан бичиг ирсэнээс 53 хариутай бичгийг хүлээн авч тухай бүрд нь холбогдох албан тушаалтанд танилцуулж хугацаатай албан бичгийн хариуг хугацаанд нь явуулсан.

**Явуулсан албан бичиг:** Нийслэлийн засаг даргын тамгын газарт 18 бичиг, Нийслэлийн соёл урлагийн газарт 7 бичиг, бусад байгууллага ААН-д 25 албан бичиг, нийт 90 албан бичиг явуулсан.

#### **www.erp.ulaanbaatar.mn-ийг ашиглан:**

**Өргөдөл гомдол:** Ажилтнуудаас хандсан өргөдөл гомдол нийт 17-г хүлээн авсанаас ажилд орох хүсэлт 7, ажлаас чөлөөлөгдөх хүсэлт 10-г хүлээн авсан.

**Тушаал:** “Б” тушаал 54 гарснаас үүнээс ажлаас чөлөөлөх 13, ажилд авах 7, цалинг шинэчлэн тогтоох 9, буцалтгүй тусламж олгох 10, ээлжийн амралт эдлүүлэх 14 тушаал гарсан байна. Үндсэн үйл ажиллагаатай холбоотой “А” тушаал 25 гаргаж, хэрэгжүүлсэн байна.

#### **/www.arch.ulaanbaatar.mn/-ийг ашиглан:**

Байгууллагын архивын системд хадгалагдаж буй 1986-2019 онд хамаарах 3073 захирамжлалын баримтын цахим баримтын агуулга, тэдгээрт хавсаргасан цахим хувь, хавсралтын бүрдэл, үг үсгийн алдааг нягтлан шалган, дутуу бүрдэлтэй баримтыг нөхөн оруулж, цахим баримтын бүртгэл үйлдэв.

Мөн 2020 оны хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг гарган байгууллагын ББНШК-оор хэлэлцүүлэн батлуулав.

### **Дөрөв. Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдал.**

**4.1. Төсөв, санхүүгийн ил тод байдлын хангаж,** төсвийн хөрөнгийн батлагдсан төлөвлөгөө, зарцуулалтын сар улирлын мэдээ, тайлан балансыг цахимаар Нийслэлийн төрийн санд өгч, шилэн дансанд тухай бүр байршуулж, байгууллагын сайтад тавьж нийтэд толилуулж ирлээ.

Мөн түрээсийн буюу үзвэр үйлчилгээ, арга хэмжээний орлогоор үйл ажиллагааны санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлж, батлагдсан төсөв, үр дүнгийн гэрээний хүрээнд зардал гарган, төсвийн санхүүжилтийг үр ашигтай зарцуулж, санхүүгийн тайланг үнэн зөв бэлтгэж, хуулийн хугацаанд тайлагнаж хэвшлээ.



## **4.2. Үйл ажиллагааны ил тод байдлыг хангаж, дараах ажлуудыг хийж, хэвшүүлээ.**

4.2.1. Нийслэлийн Засаг даргын “Мэдээллийн ил тод байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” 2012 оны А/606 дугаар захирамжийн дагуу байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдээ, мэдээллийг цаг тухайд нь цахим сайтад байршуулан, ил тод байдлыг хангаж ажиллаж ирлээ.

Мөн цаг үеийн мэдээллийн самбарыг ажилд оруулж өдөр тутмын ажил, тоглолтын график, ажлын дуудлага байрлуулж өдөр, тутмын шинэ мэдээ мэдээллээр хангаж, байгууллагын сайтыг тогтмол ажиллуулж хэвшүүлээ.

4.2.2 Үйлчилгээний ажлын ил тод байдлыг хангах зорилгоор санал, хүсэлт, сэтгэгдлийг нийтийн ариун цэвэр, угтах үйлчилгээ, үйлчилгээний ажилтны харилцааны соёлын чиглэлээр сэтгэл ханамжийн асуулгыг цахимаар болон 6 чиглэлийн асуулга хуудсаар авч хэвшүүлээ.

## **4.3 Хүний нөөцийн бодлогын ил тод байдлыг хангаж дараах ажлуудыг хийлээ.**

4.3.1. Албан хаагчдын ёс зүйн дүрмийг болон ажлын байрны сул орон тооны зарыг цахим хуудас, мэдээллийн самбарт ойлгомжтой байдлаар байрлуулж, тухай бүр шинэчилж байна.

4.3.2. Төрийн албаны хуулийн өөрчлөлттэй холбогдуулан Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг дахин боловсруулах ажил эхлээд байна.

4.3.3. Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг албадын үйл ажиллагааны онцлогийг харгалзан, албадын ажлын тайланг алба, нэгж бүрээр захирлын зөвлөлийн хурлаар оруулан хэлэлцүүлж, ажлын гүйцэтгэлийг нь дүгнэж, хэвшсэн. Улмаар албадын үйл ажиллагааны чиглэлээр нийт ажилчдын саналыг сонсож, сүүлийн хагас жилд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд тусгалаа.

### **Тав. Цаг үеийн шаардлагаар хийсэн ажлын үр дүн.**

## **5.1. Улс, Нийслэл, дүүргийн удирдлагаас ирүүлсэн шийдвэрийн хэрэгжилт.**

Дээд газраас ирүүлсэн болон Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Онцгой комисс, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн тогтоол, Нийслэлийн Засаг даргын захирамж, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын албан тоот, Улаанбаатар хотын ерөнхий менежерийн албан тоот зэрэг нийт 33 шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажилласан болно.

## **5.2. Нийслэл, дүүргийн удирдлагаас цаг үеийн асуудлаар өгсөн үүрэг даалгаварын хэрэгжилт.**

“Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцлийг хангах, сайжруулсан түлшний зөв хэрэглээг нэвтрүүлэх заавар зөвлөмжийг иргэдэд хүргэх ажиллагаанд амжилттай оролцлоо. Тухайлбал:

1. Монгол Улсын Засгийн газрын 62 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2019 оны “Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай” А/1016, “Түүхий нүүрсний тээвэрлэлт хэрэглээнд хяналт тавих тухай” А/1118 дугаар захирамжийг Улаанбаатар хотын Ерөнхий менежер бөгөөд Захирагчийн Ажлын албаны даргын 2019 оны “Сайжруулсан шахмал түлш болон түүхий нүүрсний хэрэглээ түүний зохион байгуулалтын үйл ажиллагаанд хяналт тавих албан тушаалтны хуваарь”-ийн дагуу нийслэлийн хэмжээнд сайжруулсан шахмал түлш болон түүхий нүүрсний хэрэглээ, түүний зохион

байгуулалтын үйл ажиллагаанд хяналт тавих шуурхай штабын зохицуулагчийн ажил үүргийг гүйцэтгэж ажиллалаа.



2. Дэлхийн улс орнуудад тархаад байгаа “Коронавирус /COVID-19/ цар тахлаас урьдчилан сэргийлэх, нийслэлийн иргэдийн эрүүл мэндийг халдварт өвчнөөс хамгаалах ажилд идэвх санаачлага гарган иргэдийн хөл хөдөлгөөнийг хязгаарлахад хяналт тавих-эргүүлийн үүргийг амжилттай хэрэгжүүллээ. Тухайлбал:

Манай хамт олон Коронавирусын халдвараас сэргийлэх талаар зөвлөмж зөвлөгөө өгч, эргүүлээр 2020 оны 02 сарын 20-ноос 2020 оны 06 сарын 03-ны өдрийг хүртэл тасралтгүй ажиллаж, Сүхбаатар дүүргийн 6 болон 8-р хорооны хуваарилагдсан нутаг дэвсгэрт эргүүл хийж, маскгүй явж байгаа хүмүүст шинэ коронавирусын халдвар томуу төст өвчний тархалтаас сэргийлэх зөвлөгөө зөвлөмж өгч, ариутгал цэвэрлэгээний талаар хяналт тавьж ажилласан болно. Давхардсан тоогоор 401 албан хаагчид 108 өдрийн 392 цагийн эргүүл хийсэн байна. Нийт 10000 ширхэг сурталчилгааны хуудсыг иргэд, аж ахуй нэгжүүдэд тарааж, нийт 80 аж ахуй нэгжүүдэд тогтмол хяналт тавьж зөвлөгөө өгсөн байна. Мөн эргүүлээр ажилласан албан хаагчдын нэрс, ирсэн явсан цаг, хэрэгүүлсэн ажлын зурагт тайланг Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлж өдөр бүр мэдээллэж зохих журмын дагуу ажиллаж ирлээ.









3. Дэлхий даяар тархаад буй коронавирусийн халдвар Монгол Улсад бүртгэгдсэнтэй холбогдуулан халдвараас урьдчилан сэргийлэх, тархалт хүрээг нь нэмэгдүүлэхгүйн тулд тусгай зөвшөөрөл бүхий мэргэжлийн байгууллагатай хамтран нийслэлийн хэмжээнд зохион байгуулагдаж буй ариутгал халдваргүйтгэлийн арга хэмжээнд байгууллагаа хамруулж, концертын их танхим, гадна болон дотоод орчны талбай бусад өрөө тасалгаа зэрэгт /нийт 3000 орчим метр квадрат/ талбайд ариутгал, халдваргүйжүүлэх ажлыг хоёр удаа хийлгэлээ.





4. “Дэлхийн улс орнуудад тархаад байгаа “Коронавирус /COVID-19/ цар тахлаас урьдчилан сэргийлэх, нийслэлийн иргэдийн эрүүл мэндийг халдварт өвчнөөс хамгаалах” нь байгууллага, хамт олон идэвхи санаачлага гарган, ариутгал, цэвэрлэгээг чанарын өндөр түвшинд хийх үүргийг амжилттай хэрэгжүүллээ.

Байгууллагын өрөө тасалгаа, тоног төхөөрөмжийн эмх цэгц, цэвэр цэмцгэр байдлыг хангаж, албан хаагчид их цэвэрлэгээг удаа дараа хийж гүйцэтгэлээ. Үүнд: Маркетинг үйлчилгэний албаны албан хаагчид өдөр тутмын цэвэрлэгээ үйлчилгээг тогтмол хийхийн зэрэгцээ гадна талын хана, хаяавч, “Г” корпусын 1-12 давхарын цонх, тагтнууд, “А”, “Г” корпусын зоорийн давхарт их цэвэрлэгээ хийж, их танхимын сандлуудыг угаах, наасан бохийг арилгах ажлыг 7 хоног тутам хийх их цэвэрлэгээний хуваарьт оруулж, хэрэгжүүлж ирлээ.

Уран бүтээл техникийн албаны албан хаагчид тайз, декораци, гэрэлтүүлэг, дуу дуугаралтын тоног төхөөрөмж, техникийн өрөөнүүд, галерей, бусад жижиг хэрэглэл болон агуулахын өрөөнүүдийг цэвэрлэлээ. Мөн маркетинг үйлчилгээний албан хаагчид тайз чимэглэлийн зөөлөн хөшиг, жижиг хэрэглэл, сандал, ширээ, гэрэлтүүлэг, дуу дуугаралтын тоног төхөөрөмж хадгалах өрөөнд засвар үйлчилгээ хийж, жижиг хэрэглэл тавих тавцангууд хийн суурилуулж, хөшигийг шинэчилж, хивс дэвсэж, цэвэрлэгээг тогтмол хийж, гүйцэтгэж байна.













5. Коронавирус /COVID-19/ цар тахлын үед хэрэгжүүлсэн оноож өгсөн гудамжид эргүүл хийх, байгууллагын дотор, гадна талд ариутгал цэвэрлэгээ хийх, “Сайжруулсан шахмал түлш болон түүхий нүүрсний хэрэглээ түүний зохион байгуулалтын үйл ажиллагаанд хяналт тавих, Улсын баяр наадмын арга хэмжээг үзэгчгүй, цахимаар зохион байгуулах, зэрэг ажилд төрийн бодлого, шийдвэрийг хэрэгжүүлж, идэвхи зүтгэл гарган үр дүнтэй ажилласан албадыг Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/342 дугаар, 2020 оны А/747 дугаар захирамжуудыг үндэслэн **зургаан сая** төгрөгөөр шагнаж урамшууллаа.
6. Монгол Улсын Соёлын яам, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар хамтран Нийслэлийн иргэдэд соёл, урлагийн үйлчилгээг ойртуулах, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор 2020 оны 8 дугаар сарын 26-ны өдрөөс 2020 оны 10 дугаар сарын 26-ныг дуустал өдөр бүр нийслэл хотын гудамж, талбайд үнэ төлбөргүй тоглолт, арга хэмжээ, нөлөөллийн “Соёлын Цаг” аяныг үзэгч, үйлчлүүлэгч олон нийтэд зориулан толилуулла байна.

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хүрээнд “Хотын Соёл” аяныг эхлүүлж, байгууллагын Вэбсайт болон Пэйж хуудсаар дамжуулан дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

1. “Хотын Соёл” олон нийтийн аяны хүрээнд Соёлын Төв Өргөөний “Их танхим”-д болж байгаа арга хэмжээний үед үзэгчдийн үзвэр үзэх соёлыг дээшлүүлэхэд зориулсан аудио бичлэгийг арга хэмжээ эхлэхээс өмнө тогтмол явуулж хэвшлээ.

2. Байгууллагын алба ёсны [www.stu.ub.gov.mn](http://www.stu.ub.gov.mn) вэбсайтаар дамжуулан үзэгчдийн үзвэр үзэх соёл, хувь хүний болон хотын соёлыг дээшлүүлэхэд зориулсан мэдээ мэдээллийг 7 хоног бүр тогтмол хүргэж ажиллалаа. Үүнд:

1. Вэбсайтад мэдээ үзэгчдийн үзвэр үзэх соёл, хувь хүний болон хотын соёлыг дээшлүүлэхэд зориулсан мэдээ мэдээллүүд
  - Соёлыг түгээцгээе 1. Үзвэр үзэхдээ цагаасаа хоцрохгүй байж сурцгаая.
  - Соёлыг түгээцгээе 2. Үзвэрийн дундуур хоорондоо ярихгүй байцгаая.
  - Соёлыг түгээцгээе 3. Үзвэр үзэхдээ утсаар ярихгүй байж бусдыгаа хүндэтгэе.
  - Соёлыг түгээцгээе 4. Тоглолтын танхимд хурц үнэртэй хоол хүнсний зүйл идэхгүй байцгаая.
  - Соёлыг түгээцгээе 5. Үзвэрийн дараа өлгүүр лүү битгий яараарай.
  - Соёлыг түгээцгээе 6. Тоглолтын танхимд суудлын араас өшиглөхгүй байцгаая.
  - Соёлыг түгээцгээе 7. Үзвэр үзсэн танхимдаа хогоо битгий хаяарай.
  - Соёлыг Түгээцгээе 8. "Лифтэнд суух, буух"
  - Соёлыг Түгээцгээе 9. "Баруун гарын дүрэм"
  - Соёлыг Түгээцгээе 10. Та зогсож болно, гэхдээ бусдад саад болохгүйгээр.
  - Соёлыг түгээцгээе 11. Нэгнийхээ биед аль болох хүрэхгүй байх.
  - Соёлын түгээцгээе 12. Онгоцоор хэрхэн зорчих вэ?
  - Соёлыг Түгээцгээе 13. Олон нийтийн газар ялгадсаа гаргалгүй тэвчих нь.
  - Соёлыг түгээцгээе 14. Дуут дохио, бүдүүн яндангийн чимээ, дрифтийг ямар үед хориглох вэ?

- Соёлыг түгээцгээ 15. Сайн байна уу, баярлалаа, уучлаарай, зүгээр, баяртай.
- Соёлыг түгээцгээ 16. Угаал үйлдэх нь.
- Соёлыг түгээцгээ 17. Манай гэр л цэвэрхэн бол орц хамаагүй гэвэл том эндүүрэл.
- Соёлыг түгээцгээ 18. Тагтнаасаа эсвэл цонхоороо дээж өргөж болохгүй гэдгийг ээждээ хэлээрэй.
- Соёлыг түгээцгээ 19. Театрт очих нь баярт очихтой адил.
- Соёлыг түгээцгээ 20. Кинотеатрт биднийг юу бухимдуулдаг вэ?
- Соёлыг түгээцгээ 21. Улаанбаатарын бохир гудамжууд.
- Соёлыг түгээцгээ 22. Бусдын асуудлыг шийдэх гээгүй бол түүний хэрэгт бүү дурла.
- Соёлын түгээцгээ 23. Харилцаанаас харилцаа үүсдэг.
- Соёлыг түгээцгээ 24. Үйлчилгээ уур бухимдал бус талархал дагуулах ёстой.
- Соёлыг түгээцгээ 25. Урдуур дайрахыг овсгоо гэж бүү эндүүр.
- Соёлыг түгээцгээ 26. Нэрийн хуудас хадгалдаг эсвэл аваад хаядаг “цаас” биш.
- Соёлыг түгээцгээ 27. Урилга хүлээн авч байгаа нь очно гэдгээ илэрхийлж буй хэрэг.
- Соёлыг түгээцгээ 28. Ширээн доогуур тонгойн “хуралтай байна” гэж битгий хэлээрэй.
- Соёлыг түгээцгээ 29. Ажил хэрэгч болон ганган байхын хооронд том ялгаа бий.
- Соёлыг түгээцгээ 30. Мэдээлэл авч, дамжуулахдаа эргэлзэх "эрх"-ээ эдлэх нь.
- Соёлыг түгээцгээ 31. Автобусанд худлаа ярьж, хөл дээр гишгэж, хэт наалдахаа больё.
- Соёлыг түгээцгээ 32. Хогийг зөвхөн хогийн саванд хаяцгаая.
- Соёлыг түгээцгээ 33. Бэлэн мөнгөөр олон төрлийн нян дамждаг. Мөнгөө цахим болгоё.
- Соёлыг түгээцгээ 34. Хотод амьдрах гэж байгаа хүн бүрд хэрэгтэй зөвлөгөө.
- Соёлыг түгээцгээ 35. Жендерийн зарим хэвшмэл ойлголтоос салах нь.
- Соёлыг түгээцгээ 36. Гэр бүлийнхээ гишүүдтэй хуваалцаж болохгүй 10 зүйл.
- Соёлыг түгээцгээ 37. “Тамхилах” нэрээр эрэгтэй хүүхдийн биед хүрэхээ больцгооё.
- Соёлыг түгээцгээ 38. Эрээ цээргүй ширтэх нь ажлын байрны бэлгийн дарамт болдог.



2. Байгууллагын алба ёсны “Соёлын Төв Өргөө” Facebook хуудасны ковер зургийг “Хотын Соёл” олон нийтийн аяны алба ёсны зургаар сольж ажилласан.



3. Нийслэлийн Соёл Урлагийн газраас гаргаж буй цуврал нэвтрүүлэг, видео, контентийг “Соёлын Төв Өргөө” Facebook хуудсаар дамжуулан олон нийтэд давалгаалж сурталчилахыг ажлыг тухай бүрт хийж ажиллалаа
4. Аяны хүрээнд Нийслэлийн Соёлын Төв Өргөө, Сүхбаатар Дүүргийн Засаг Даргын Тамгын Газар хамтран Сүхбаатар дүүргийн нутаг дэвсгэрийн Хонхтой цэцэрлэгт хүрээлэн, хичээнгүй сайд Б.Цэрэндоржийн гудамж, Улсын драмын эрдмийн театрын талбайд арга хэмжээ зохион байгуулж, ард иргэдэд соёл урлагийн үйлчилгээг хүргэлээ. “Соёлын Цаг” аяны хүрээнд:

### Соёлын цаг хөтөлбөр

Нийслэлийн иргэдэд соёл, урлагийн үйлчилгээг ойртуулах, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор Соёлын яам, Нийслэлийн Засаг даргын Тамгын газартай хамтран 2020 оны 8 дугаар сарын 26-ны өдрөөс эхлэн 2020 оны 10 дугаар сарын 26-ныг дуустал өдөр бүр нийслэл хотын гудамж, талбайд иргэд, олон нийтэд зориулсан үнэ төлбөргүй тоглолт, үйл ажиллагаа, нөлөөллийн аян зохион байгуулж байна.

Энэхүү аян “Соёлын Цаг” хөтөлбөрийн хүрээнд Нийслэлийн Соёлын Төв Өргөө, Сүхбаатар Дүүргийн Засаг Даргын Тамгын Газартай хамтран Сүхбаатар дүүргийн нутаг дэвсгэр болох Хонхтой цэцэрлэгт хүрээлэнд, Хичээнгүй сайд Б.Цэрэндоржийн гудамж, Улсын драмын эрдмийн театрын талбайд болж буй арга хэмжээг зохион байгуулж Сүхбаатар дүүргийн ард иргэдэд соёл урлагийн үйлчилгээг хүргэн ажиллаж байна.



Д/Д	Он сар өдөр	Цаг	Мэргэжлийн урлагийн байгууллагын нэр	Уран бүтээлчдийн тоо	Үзэгчдийн тоо	Хариуцсан байгууллага
1	2020.08.26	18:00	Улсын драмын эрдмийн театр	21	80	СБД-ЗДТГ-1 Соёлын төв өргөө-2
Нийт					<b>80</b>	
	2020.08.27	12:00	Улаанбаатар чуулга	17	80	СБД-ЗДТГ-1 Соёлын төв өргөө-2
		15:00			100	
		18:00			50	
Нийт					<b>230</b>	
	2020.08.28	12:00	Хүүхэлдэйн театр	14	160	СБД-ЗДТГ-1 Соёлын төв өргөө-2
		15:00			100	
		18:00			60	
Нийт					<b>320</b>	
	2020.08.29	12:00	Цэргийн дуу бүжгийн эрдмийн чуулга	68	120	СБД-ЗДТГ-1 Соёлын төв өргөө-2
		15:00			200	
		18:00			100	
Нийт					<b>420</b>	
	2020.09.02	12:00	Үндэсний урлагын их театр	30	200	СБД-ЗДТГ-1 Соёлын төв өргөө-2
		15:00			120	
		18:00			110	
Нийт					<b>430</b>	
	2020.09.03	12:00	Хилийн цэргийн дуу бүжгийн чуулга	30	300	СБД-ЗДТГ-1 Соёлын төв өргөө-1
		15:00			100	
		18:00			80	
Нийт					<b>480</b>	

	2020.09.05	12:00	Улаанбаатар чуулга	18	100	Бороо орсон тул цуцлагдсан
		15:00			60	
		18:00			-	
Нийт					<b>160</b>	
	2020.09.06	12:00	Монгол Улсын Филормони	17	100	СБД-ЗДТГ-1 Соёлын төв өргөө-2
		15:00			80	
		18:00			30	
Нийт					<b>210</b>	
	2020.09.07	12:00	Хүүхэлдэйн театр	18	150	
		15:00			100	
		18:00			120	
Нийт					<b>370</b>	
	2020.09.08	12:00	Дуурь бүжгийн эрдмийн театр	17	120	СБД-ЗДТГ-1 Соёлын төв өргөө-2
		15:00			100	
		18:00			100	
Нийт					<b>210</b>	
	2020.09.09	12:00	Цэргийн дуу бүжгийн эрдмийн чуулга	18	110	
		15:00			80	
		18:00			70	
Нийт					<b>260</b>	
	2020.09.10	12:00	Улсын Драмын Эрдмийн Театр	17	80	СБД-ЗДТГ-1 Соёлын <sup>43</sup> төв өргөө-2
		15:00			90	
		18:00			70	
Нийт					<b>240</b>	



Өдөр бүр хуваарийн дагуу мэргэжлийн байгууллагын тоглолтыг Сүхбаатар дүүргийн ард иргэдэд хүргэн ажиллаж байна.

Соёлын цаг хөтөлбөрийн тоглолтын зураг



















ЗӨВШӨӨРСӨН:

ЗАХИРАЛ  Б.БАЙГАЛМАА

НЭГТГЭН ГАРГАСАН:

ХҮНИЙ НӨӨЦИЙН МЭРГЭЖИЛТЭН  П.СЭРСМАА